МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МАГАДЛАЛ ХИЙСЭН ТУХАЙ

ДҮГНЭЛТ

2024 оны 08 дугаар сарын 30 Дугаар 381/04-194 Улаанбаатар хот

“СМАРТ ПРОЖЕКТ ” ХХК-Д

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1.Барилга байгууламжийн байршил: Баянгол дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийслэлийн ерөнхий боловсролын 13 дугаар сургуулийн 640 хүүхдийн дунд сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөл.

2.Зургийн шифр, зураг төслийн компани: СП-01/2024 “Смарт прожект” ХХК.

3.Барилга байгууламжийн зориулалт: Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/593 дугаар шийдвэртэй, 2.0168 га газартай, 2024 оны 6 дугаар сарын 04-ний өдөр баталсан 2024/00-075 дугаар даалгавартай сургуулийн барилгын ажлын зураг

4.Барилгын давхар, талбай, эзэлхүүн: 3 давхар,

5.Галд тэсвэршилтын зэрэг: төлөвлөсөн: II

6.Барилгын үүргийн галын аюулын анги: Ф 1.1

7.Зургийн иж бүрдэл: 2 хэсэг

Хоёр. Дүгнэлт

1. Барилгын хананы гадна дулаалгын материалд ШҮ үзүүлэлттэй барилгын материалыг ашиглах ба шинжилгээнд оруулсан дүгнэлттэй байх. / ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгээс авсан/.

2. Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбД 30-01-04-ийн заавал биелүүлэх 4 дүгээр хавсралтад заасан гал тусгаарлах хамгаалалтын зай хэмжээг баримтлах.

3. Гонх болон шатны хонгилын хаалга нь 1.2 цагийн гал тэсвэршилттэй өөрөө хаагдах төхөөрөмжөөр тоноглогдсон, түлхүүр хэрэглэхгүй онгойх горимтой, нягтруулагчтай байх шаардлагатай.

4. Галын дохиоллын мэдээлэгчийн байрлалыг технологийн байгуулалт, дам нуруу, хана, хүртэлх зай, мэдээлэгчийн хүчин чадалтай уялдуулж, өндрийн хэмжээг тооцож галын дохиоллын хэрэгслийг сонгож төлөвлөн түүний дагуу гүйцэтгэх. /БНбД 21-04-05/.

5. Галын дотор усны даралтад цэгийн холбох тотгыг гал унтраах багаж зэвсэглэмжтэй холбож болохоор тооцож угсарна. /Ф51мм-ийн Богданов төрлийн/ Гал унтраах хоолойн уртыг орон зайн аль ч хэсэгт хүрэхээр тооцно.

Дээрх шаардлагыг биелүүлснээр тус ажлын зураг нь галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа болно.

Зөвшөөрсөн сар, өдөр	Зөвшөөрлийн тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл
2024.08.30	Нүүр хуудас, ЕТ-3, БА-3,4,5,6,7, ХД-9,10, 11,12, ХАС-13,14,15,16,17,18,19,20, ЦБУ-9,10,11,12,	Барилгын ажлыг зураг төслийг дүгнэлтийн дагуу гүйцэтгэх

ДҮГНЭЛТ ГАРГАСАН
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ТЕХНИКИЙН
ГҮЙЦЭТГЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН,
ДЭД ХУРАНДАА М.БАТСАЙХАН